



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Торийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategrw@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2025.02.10 № 10

Орон сууцны ипотекийн зээлийн  
зохицуулалтын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн ипотекийн зээлийн зохицуулалт, хүртээмж, шударга байдал, хот төлөвлөлтийн бодлого, орон сууцны зах зээлийн тогтвортой байдалд чиглэсэн арга хэмжээнүүдийн боломж, нелөөллийг судлах зорилгоор дараах асуултыг Танд тавьж байна.

Нэг.Ипотекийн зээлийн талбайн хязгаарыг 120м<sup>2</sup> хүртэл нэмэгдүүлэх боломжтой эсэх. Энэ хүрээнд:

- Одоогийн ипотекийн зээлийн хязгаарлалт нь том талбайтай орон сууц худалдан авах боломжийг хязгаарлаж байна. Ялангуяа олон хүүхэдтэй айл өрхүүд хангалттай орон зайд бүхий орон сууц сонгоход хүндрэлтэй байдал үүсэж, амьдрах орчны таатай нөхцөл бүрдэхэд саад болж байна. Хэрэв энэ хязгаарыг нэмэгдүүлбэл орон сууцны нийлүүлэлт, үнэ, зах зээлийн эрэлт, иргэдийн зээлийн хүртээмжид хэрхэн нелөөлех вэ?

Хоёр.Ипотекийн зээлийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан зөвхөн гэр хорооллын дахин төлөвлөлтийн бус болон Сэлбэ, Баянхшуу, Шархад, Толгойт зэрэг дэд төвүүдэд чиглүүлэх боломжтой эсэх. Энэ хүрээнд:

- Энэ арга хэмжээ нь гэр хорооллын бусэд орон сууцны төсөл хэрэгжүүлэхийг дэмжиж, хотын тэнцвэртэй хөгжлийг хангах ач холбогдолтой. Ийм бодлого хэрэгжүүлснээр орон сууцны нийлүүлэлт, үнэ, тухайн бусийн хөгжлийн хандлагад хэрхэн нелөөлех вэ?

Гурав.Ипотекийн зээлийн хүсэлт гаргасан иргэдийн дарааллыг ил тод, нээлттэй болгох үүргийг банкнуудад ногдуулах боломжтой эсэх. Энэ хүрээнд:

- Одоогоор банкнууд ипотекийн зээлийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэж буй нь олон нийтэд тодорхой бус байна. Хэрэв энэ үйл явцыг ил тод болговол иргэдийн хүлээлт, итгэлцэл, хүртээмжид ямар нелөө үзүүлэх вэ?

- Бага, дунд орлоготой болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн зээлийн хүсэлтийг тэргүүн ээлжид шийдвэрлэхээр эрэмбэлэх боломжтой эсэх.

Эдгээр асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Г. МУРА

Г.ЛУВСАНЖАМЦ



2025000010